

# БАЯНБОГД ХК

2015 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалт, "Баянбогд" ХК-ийн 2015 оны 4-р сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2014 оны ТУЗ-ийн дүгнэлт бүхий үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайланг зөвшөөрч БАТАЛСУГАЙ.

ХУРЛЫН ДАРГА



Г. ХАТАНБОЛД

# БАЯНБОГД ХК

2015 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

### Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.1 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 162-р тогтоол болон “Баянбогд” ХК-ийн 2015 оны 4-р сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн оноосон нэрийг нэгдэж буй компанийн нэрээр “Стандарт проперти групп” болгон ӨӨРЧИЛСҮГЭЙ.
2. Компанийн шинэчилсэн дүрмийг Хавсралт №1-ээр БАТАЛСУГАЙ.
3. Компанийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 97,607 ширхэг хувьцааг нэгдэж буй компанийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,530,200 ширхэг хувьцаагаар нэмэгдүүлэн, нийт нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,627,807 ширхэг хувьцаа болгон ӨӨРЧИЛСҮГЭЙ.
4. Эдгээр өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулж, Улсын бүртгэлийн газарт хуульд заасан хугацаанд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал Г.Лхамсүрэн-д үүрэг БОЛГОСУГАЙ.

ХУРЛЫН ДАРГА



Г.ХАТАНБОЛД

# БАЯНБОГД ХК

2015 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

### Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 дэх заалт, "Баянбогд" ХК-ийн 2015 оны 4-р сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр СОНГОСУГАЙ.  
Үүнд:
  - Ердийн гишүүд
  - Г.Хатанболд
  - Г.Лхамсүрэн
  - Н.Улаанхүү
  - Ричард Кобаяаши
  - Хирохито Намики
  - Татааки Кавазое
2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр СОНГОСУГАЙ.  
Үүнд:
  - Хараат бус гишүүд
  - Х.Үнэнхүү
  - Д.Лхагва-эрдэнэ
  - С.Лхамчимэг
3. Компанийн үр ашигтай ажиллагааг хангаж, хууль журмын дагуу удирдан зохион байгуулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд ҮҮРЭГ БОЛГОСУГАЙ.

ХУРЛЫН ДАРГА



Г.ХАТАНБОЛД

# БАЯНБОГД ХК

2015 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

### Төлөөлөн удирдах зөвлөлийн сонгуульт жилийн зардлын төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.13 дэх заалт, "Баянбогд" ХК-ийн 2015 оны 4-р сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн сонгуульт жилийн зардлын төсвийг 1-р хавсралтаар нийт 56,300,000/тавин зургаан сая гурван зуун мянга/ төгрөгөөр БАТАЛСУГАЙ.

ХУРЛЫН ДАРГА



Г. ХАТАНБОЛД

"Баянбогд" ХК-ийн 2015 оны 4-р сарын 30-ны өдрийн  
Хувьцаа эзэмшигчийн ээлжит хурлын №04 тогтоолын Хавсралт 1



**"Баянбогд" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн сонгуульд жилийн зардлын төсөв**

№	Зардлын төрөл	Нэгж зардал /төгрөгөөр/	Орон тоо	Давтамж	Нийт дүн /төгрөгөөр/
1	ТУЗ-ийн даргын цалин	250,000	1	12	3,000,000
2	ТУЗ-ийн гишүүдийн цалин	200,000	8	12	19,200,000
3	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин	200,000	1	12	2,400,000
4	ТУЗ-ийн хурлын зардал	150,000		4	600,000
5	Хувьцаа эзэмшигчийн хурлын зардал	500,000		1	500,000
6	Томилолтын зардал /Япон руу/				6,000,000
	Нийт дүн				56,300,000



# БАЯНБОГД ХК

2015 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

### Ногдол ашиг хуваарилахгүй тухай

“Баянбогд” ХК-ийн 2015 оны 4-р сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Баянбогд” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2014 онд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэснийг БАТАЛСУГАЙ.

ХУРЛЫН ДАРГА



Г. ХАТАНБОЛД